

УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

МОНГОЛ ХЭЛ

XII АНГИ

Аймаг/дүүрэг:

Сум:

Сургууль:

Анги: Бүлэг:

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Судар ном залсан газарт өлзий хутаг оршино

Хээр тал нутгийн нүүдэлчин айлын хүүхэд би номын амтанд хожуухан орсон юм. Манай гэрийн хойморт шар баринтагтай нэг судар байдаг сан. Ном хэмээх ертөнцийн барааг анх харсан минь тэр. Ээж минь орой болгон унтахын өмнө судраа бариад гэр хотоо гурвантаа эргэж, бидэнд адис өгөөд хоймортоо буцаан залдаг сан. Нэгэн өдөр аав судраа задлан шарлаж хуучирсан хуудаснуудыг нь эргүүлж байхыг хараад:

-Аав аа, энэ номд юу гэж бичсэн байгаа юм гэж асуухад, аав минь өхөөрдөнгүйгээр

-“Өлзий хутаг” нэртэй ном юм. Аав нь Төвөд үсэг мэдэхгүй болохоор дотор юу гэж байгааг ухаж ойлгохгүй юм даа гэв.

-Аав аа, тэгвэл та яагаад уншиж буй юм шиг эргүүлээд байгаа юм бэ гэж гайхан асуухад

-Номын үсэг бол уншиж мэдэхгүй байсан ч гэгээн утгаа өөрөөсөө үргэлж цацрааж байдаг юм. Энэ ном манай гэрт баяр баясгалан, эрүүл саруул, аз жаргал, амар амгаланг соёрхож бид ч номын гэгээнд энх мэнд сайхан аж төрж байгаа юм даа гээд магнай дээр үнэрлэсэнээ

- Номд бичсэнийг харсан тэнгэрүүд маань дээрээс уншиж таалсан байх аа. Одоо бүх юм улам сайхан болно. Бороо хур тэгширч, цэцэг ногоо дэлгэрч, даяараа жаргана аа хэмээн судраа хичээнгүйлэн баринтаглаж билээ. Аавынхаа хэлсэн үгээр аливаа судар ном залсан газарт сайн сайхан бүхэн цуг оршдог гэж бат нот итгэдэг болсон юм.

Хөдөө сумын сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд сурах бичгээс өөр юм олдох ч биш дээ. Намайг дөрөвдүгээр анги төгсөх хавар манай сумын дэлгүүрт овоо хэдэн ном ирсэн байна. Хадгалж байсан бутархай мөнгөнүүдээ цуглуулж гурван төгрөг болгоод “Мянга нэгэн шөнийн үлгэр” хэмээх ном худалдаж авлаа. Удалгүй зуны амралт болж хөдөө гэртээ хариад мөнөөх номоо уншиж гарав. Гайхалтай байлаа. Тэр номыг уншиж байхдаа уйлах, ичих, гайхах, бахархах бүгдийг л мэдрэв. Ингэж дөрөвдүгээр ангийн хүү би өөртөө ахадсан Арабын “Мянга нэгэн шөнийн үлгэр”-ийн амтанд орж ном гэдэг ямар гоё салж хагацашгүй сайхан зүйл болохыг анх мэдэрсэн юм. Манай гарамгай орчуулагч Самбуугийн Бадраа гуай тэр номыг сэтгэлд буутал яруу сайхан хэл найруулгаар орчуулсан байж, түүнийг би тунгалаг булгийн ус залгилах мэт шимтэн хүртжээ.

Зургаадугаар өвлийн амралтаар гэртээ харьж чадсангүй. Аз болоход сумын төвд холын садан болох Самдан хэмээх лам байсан өвгөнийд арав хонов. Тэр өвгөнд хуучин судруудтай хамт тавь, жараад онд гарсан шинжлэх ухааны хялбаршуулсан илтгэлүүд дугаараараа байж таарсан юм. Тив дэлхий яаж тогтдог тухай, тэнгэр яагаад дуугардаг тухай, байгалийн элдэв хачин үзэгдлүүд, солирын тухай гэх мэт олон сонирхолтой мэдээллүүд агуулсан байв... Санаанд О. Намнандорж гуайн нэр их тод үлджээ. Ингээд би зөвхөн утга зохиолын уншигч бус, шинжлэх ухаан танин мэдэхүйн номын хорхойтон болох зам руу орчихсон юм. Гэхдээ л хөдөөгийн хүү надад сайхан ном үргэлж дутагдаж байлаа.

Ахиад нэг аз тохиов. Арван наймтайдаа багшийн диплом өвөртөлсөн жаал хүү би бээр Замын –Үүд хэмээх хилийн бөглүү тосгонд бага ангийн багшаар томилогдов. Хичээл арайхан эхлээгүй, анги танхимаа янзалж дуусаад, тосгоны халуун усны шүршүүрт орж байтал миний хажуугийн шүршүүрт орж байсан шавилхан шар залуу ноомой дуугүй миний хэл амыг сугалчих шахдаг юм. Тосгоны гал командад ажилладаг гэнэ. Алсдаа сэтгүүлч болж, цахиур хагална л гэнэ. Шүлэг бичдэг үү? гэж надаас асуугаад өөрөө Сергей Есенинд дуртай л гэнэ. Ийнхүү ирээдүйн нэрт сэтгүүлч Ш.Цэрэнпил бид хоёр нам гүмхэн хөдөө тосгонд номоор дамжин дотносон үерхсэн юм. Ш.Цэрэнпил маань нэгэн өдөр надад Америкийн ерөнхийлөгч Б.Рузвельтын номтой нөхөрлөсөн түүхийг ярьж өгөөд “Түүний ерөнхийлөгч болсон, өгсүүр замыг товчилсон амжилтын нууц нь ном хурдан уншдаг байсан явдал юм” гэж сургав. Тэгээд хоёул ном хурдан уншдаг аргад суралцахаар шийдсэн юм.

Гурван жилийн дараа УБДС-ийн монгол хэл, уран зохиолын ангийн оюутан болсон би гурван ч номын сангийн уншигчийн үнэмлэхтэй болж аваад мөнөөх хурдан уншдаг болох мөрөөдлөө биелүүлэхээр шийдэв. Бидний оюутан байх үед социалист

үзэл суртал оргилдоо хүрч асан цагтай давхацдаг бөгөөд Маркс, Ленин, Энгельсийн ботиудыг толгой дараалан уншив... Дүн тавиулахын тулд унших ёстой. Тэдгээр номуудыг уншихын хажуугаар монголын түүх соёлтой холбоотой ховор чухал номууд, дэлхийн болон монголын эртний сонгодог уран зохиол, шашны ховор живэр номуудыг зэрэгцүүлэн тавиад үздэг сэн. Ягштал нухацтай судалж амжаагүй ч олонход нь гар хүргэж, нүдээ чилээж амжсан даа. Залуу цагийн тархи сэргэг, ой ч саруулхан байж, шалгалт өгч байхад зарим номын хуудас тархин дотор зурагтын дэлгэц дээрх шиг тов тодорхой харагдан байж билээ. Өөрт ургаж гарч ирсэн ой тогтоолтыг, тэрхүү содон чадварыг төдийлөн хөгжүүлж чадаагүй минь харамсалтай. Гэхдээ номын санд ч юм уу, дэлгүүрт ороод барьж авсан номынхоо хуудсыг гүйлгэн эргүүлэх зуур уг бүтээлийн тоймыг багцаалан авч болдог нь судас барьдаг маарамбатай төстэй гэх үү дээ. Номыг нээгээд заавал бүх хуудсыг эргүүлж ерөнхий тойм мэдээллийг авч хорхойгоо дарна. ...Ингээд би аажимдаа номын санд суухаа больж зөвхөн гэрийнхээ номын сангаас бараг л бүхий л асуултдаа хариулт авдаг болсон доо.

Сайхан ном бол амьд эрчимтэй. Магадгүй, би номыг илүү амталж, номдоо нэвтэрч уусаж уншдаг уншигч байж болох юм.

“Гэгээнтэн” романтай холбогдох ном судар, бичиг баримт, лавлагааны материал гэхэд олон он дамжаад миний номын санд санаандгүй л цугларчихсан байсан. Романаа ид бичиж байх үед олон цагаар толгой татахгүй суусаар түр амсхийх зуур дадсан дадлаараа номын сангаасаа нэг ном сугалж огт санаандгүйгээр дэлгэхэд түрүүхэн тулгамдаж байсан асуултад хариу болох үг өгүүлбэрүүд дурайж байх нь тэр. Нэгэн удаа ийм явдал болсон бол санаандгүй гэх сэн. Гэтэл бараг өдөр болгон ийм явдалтай таарч байлаа. Миний номууд бид хоёрын хооронд зөн билиг ч гэмээр, ойлголцол ч гэмээр холбоос бий болсон бололтой. Эзнээ олж ирсэн ном бол бурхнаас илгээгдсэн мэргэн зөвлөгч, зөн билигт анд нөхөр ажгуу.

Сайн номоор сайхан номын сан бүтээх нь өндөр орд харш цогцлоосноос илүү үнэт баялаг өв хөрөнгө, буян хишгийн дээд буюу.

Г. Мэнд-Ооёо

Даалгавар 1. Эхийг бүтцээр нь зөв зааглан ялгаж, хэсэг бүрд өгүүлэгдэж буй агуулгаар нэр өгөөрэй. (2 оноо)

Эхлэл хэсэг:

Гол хэсэг:

Төгсгөл хэсэг:

Даалгавар 2. Эхээс нийгмийн болон соёлын хам сэдвийн жишээ нэг нэгийг олж бичээрэй. (2 оноо)

Нийгмийн хам сэдэв:

Соёлын хам сэдэв:

.....

.....

.....

Даалгавар 3. Эхэд ямар асуудлыг гол болгон хөндсөн байна вэ? Тэрхүү асуудлаа чухал гэдгийг ямар баримтуудаар баталсан байна вэ? (3 оноо)

Асуудал

Баримт

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Даалгавар 4. Эхээс гол санааг илэрхийлж буй өгүүлбэрийг олж бичээд, яагаад гол санаа гэж бодож буйгаа батлан тайлбарлаарай. (3 оноо)

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэр:

.....

.....

.....

Тайлбар:

.....

.....

Даалгавар 5. Эхэд зохиолч “Номын үсэг бол уншиж мэдэхгүй байсан ч гэгээн утгаа өөрөөсөө үргэлж цацрааж байдаг” үзжээ. Хэрэв чи зохиогчоос эсрэг үзэл бодолтой байвал түүнийгээ ямар баримт ашиглан илэрхийлэх вэ? Чиний сонгосон баримтад хүн итгэж, чамтай санал нэгдэхээр байх хоёр баримтыг бичээрэй. (3 оноо)

Баримт 1:

.....

.....

.....

.....

.....

.....

Баримт 2:

.....

.....

.....

.....

.....

.....

Засагч багш нарт:

Шалгалтын материалыг засаж оноожуулахаас өмнө засалт хийх багш нар бүгд материалыг уншиж, оноо өгөх нэгдсэн нэг ойлголттой болно.

Боломжтой бол засагч багш нар ажлаа хуваарилахдаа материалын тоог тэнцүүлж, таван багшид дөч дөчин материал гэх биш, бүх шалгуулагчийн 1-3-р даалгаврыг нэг багш, 4-7- даалгаврыг нэг багш, 8-р даалгаврыг гурван багш гэх мэтээр хуваарилах. Энэ нь шалгалтын дүн үнэн зөв, шударга, бодитой байхад эерэг нөлөөтэй.

Шалгалтыг зөвхөн 0, 1, 2, 3 гэх мэт бүхэл оноогоор дүгнэнэ. 0.5, 1,5, 2,5 гэх мэт бутархай оноог ямар ч тохиолдолд өгөхгүй.

Оноо өгөх зарчим:

Даалгавар 1. Нийт 2 оноо

Эхийн бүтцийг зөв зааглан агуулгыг хангахуйц нэрлэсэн бол 2оноо

Эхийн бүтцийн аль нэг хэсгийг буруу заагласан эсвэл аль нэг хэсэгт оноосон нэр тохиромжгүй бол 1 оноо

Эхийн бүтцийг бүхэлд нь буруу заагласан, хэсгүүдэд оноосон нэршил тохиромжгүй эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

Даалгавар 2. Нийт 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс нэг нэг жишээ татан бичсэн бол 2 оноо

Нийгмийн болон соёлын хам сэдвээс аль нэгийг нь бичсэн эсвэл хоёул нэг хам сэдвийг илтгэж байвал 1 оноо

Сонгосон хэсэг нь хам сэдэв илтгэхгүй, хамааралгүй зүйл байх эсвэл даалгаврыг гүйцэтгээгүй бол 0 оноо

Даалгавар 3. Нийт 3 оноо

Эхэд гол болгон дэвшүүлсэн асуудлыг олсон бол 1 оноо

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв олоогүй бол 0 оноо

Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт 2 ба түүнээс дээш олж бичсэн бол 2 оноо /баримтууд гэж олон тоо заасан байгааг сурагч анзааран бичсэн байх ёстой/
Асуудлыг тодруулахад чухал үүрэгтэй буюу санаагаа баталсан баримт нэгийг олж бичсэн бол 1 оноо

Олж бичсэн баримт нь санааг дэмжээгүй, утга, агуулгын зөрөөтэй бол 0 оноо

Даалгавар 4. Нийт 3 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон бол 2 оноо

Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олсон боловч, өөр өгүүлбэр хамт бичсэн эсвэл цогцолбороор нь авсан бол 1 оноо

Эхийн гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж чадаагүй бол 0 оноо

Өөрийн үгээр зөв тайлбарласан бол 1 оноо

Гол санааг буруу тайлбарласан эсвэл сонгосон өгүүлбэртэй хамааралгүй зүйлс бичсэн бол 0 оноо

Даалгавар 5. Нийт 3 оноо

Сонгосон баримт нь (1) зохиогчийн үзэл бодлын эсрэг байр сууринаас хандсан, (2) шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой эх сурвалжтай, (3) үнэн зөв, ёс зүйн болон оюуны өмчийн зөрчилгүй бол 3 оноо. (1), (2), (3)-ыг тус бүр 1 оноогоор дүгнэж, аль нэгийг хангаагүй тохиолдолд оноог хасна. Мөн нэг баримт дутуу бичсэн бол 1 оноо хасна.

Даалгавар 6. Нийт 2 оноо

Хэлцийг дэлгэрүүлсэн өгүүлбэр зөв бүтэцтэй, найруулгын ямар ч алдаагүй бол 1 оноо

Өгүүлбэрт бүтэц найруулгын алдаа гарсан бол 0 оноо

Хэлц өгүүлбэрийг “гэ-, хэмээ-“ холбох үг ашиглан дэлгэрүүлсэн бол 1 оноо

XII ангийн агуулгаар үзэж судалсан “гэ-, хэмээ-“ холбох үгсийг ашиглаагүй бол 0 оноо

Даалгавар 7. Нийт 5 оноо

0-1 алдаатай хөрвүүлсэн бол 5 оноо

2-3 алдаатай хөрвүүлсэн бол 4 оноо

4-5 алдаатай хөрвүүлсэн бол 3 оноо

6-7 алдаатай хөрвүүлсэн бол 2 оноо

8-9 алдаатай хөрвүүлсэн бол 1 оноо

10 ба түүнээс дээш үг алдаатай хөрвүүлсэн бол 0 оноо

Даалгавар 8. Нийт 20 оноо

агуулаа	оноо өгөх заавар	ОНОО
Сэдэв ба зорилго	Зорилгоо хангаж бодит шийдэл санал болгож, учир шалтгааны уялдаа холбоотой сайтай бичсэн бол	5
	Учир шалтгааны уялдаа холбоо бага зэрэг алдагдсан бол	4
	Учир шалтгааны уялдаа холбоо муутай ч нэгэн сэдвээр бичсэн бол	3
	Сөрөг хандлагатай эсвэл хэд хэдэн асуудлыг хөндсөн бол	2
	Ямар нэгэн зохиол бүтээлээс санаа авсан, санааг давтсан бол	1
	Сэдэв, зорилгоос хазайсан, хуулсан бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Эшлэл баримт	Эшлэл, баримтыг оновчтой ашигласан бол	2
	Тохиромжгүй ч эшлэл, баримттай бол	1
	Эшлэл, баримтгүй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичлэгийн хэлбэр төрөл	Тодорхой хэрэгжүүлж болохуйц бодитой шийдлийг санал болгож байгаа бол	2
	Тодорхой шийдэл санал болгосон ч бодитоор хэрэгжих боломжгүй бол	1
	Ямар нэгэн бодит шийдэл санал болгоогүй, шүүмжийн шинжтэй бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бүтэц	Эхийн бүтэц ойлгомжтой, догол мөр, зайгаар заагласан бол	3
	Эхийн бүтэц ойлгомжтой хэдий ч догол мөр зайгаар зааглаагүй бол	2
	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн аль нэг нь дутуу бол	1
	Эхийн бүтэц тодорхой зааггүй, санаа бүрэн биш бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Хэл зүй, найруулга	Хэл зүй найруулгын алдаагүй	3
	Хэл зүй найруулгын багахан алдаатай ч ерөнхий цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгад нөлөөлөөгүй бол	2
	Хэл зүй найруулгын алдаа нь тухайн цогцолбор болоод бичвэрийнхээ найруулгыг сулруулсан бол	1
	Хэл зүй найруулгын алдаа их бол /4+ алдаа/	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Үгийн тоо	250-280 хооронд бол	1
	Үгийн тоо их, бага бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Зөв бичгийн дүрэм	0-1 алдсан бол	3
	2-5 алдсан бол	2
	6-9 алдсан бол	1
	10+ бол	0
	<i>хийгээгүй бол</i>	X
Бичгийн соёл	Уншиж ойлгоход саадгүй бол /дармал байж болно/	1
	Уншиж ойлгоход хэцүү, үсэг, тэмдэг хооронд ялгаагүй бичсэн бол.	0
	<i>хийгээгүй бол</i>	X